

178
175

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА, МОНГОЛЫН АНЧДЫН НИЙГЭМ-
ЛЭГИЙН ТӨВ ЗӨВЛӨЛИЙН ХАМТАРСАН ТОГ-
ТООЛ

1989 оны 5 дугаар
сарын 11 -ны өдөр

Дугаар 75/07

Улаанбаатар
хот

Анчдын байнгын бригадыг татан
буулгах тухай

Улаанбаатар хотын Анчдын байнгын бригадад агналт зохион байгуулах өөрийн эзэмшил нутаггүй, ангийн үс, агнуурын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх улсын төлөвлөгөө өгөгддөггүй, жил бүр хотоос алс хол аймаг сумын нутагт очиж 5,0-6,0 мянган тарвага, цөөн тооны буга согоо агнаж байгаа нь зардал чирэгдэл ихтэй, үр ашиг муутайгаас гадна Төв аймагт Анчдын байнгын бригад байгуулах шаардлагатайг харгалзан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Монголын анчдын нийгэмлэгийн төв зөвлөлөөс ТОГТООХ нь:

✓ 1. Улаанбаатар хотын Анчдын байнгын бригадыг 1989 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

✓ 2. Анчдын байнгын бригадын эзэмшилд байгаа үндсэн ба эргэлтийн хөрөнгө /хашаа, байшин машин техник, тоног төхөөрөмж, аж ахуйн эд хогшил/-ийг Анчдын нийгэмлэгийн төв зөвлөлд балансаас балансад шилжүүлэхийг Анчдын байнгын бригад /н.Мишиг/-д даалгасугай.

3. Анчдын байнгын бригадын "УАЗ-452" машиныг спорт агнуур зохион байгуулах, хяналт шалгалтын ажлын зориулалтаар Улаанбаатар хотын Анчдын нийгэмлэгийн зөвлөлд, "ИЖ-ЮПИТЕР" маркийн мотоцикль 3 ширхэгийг хотын Байгаль орчныг хамгаалах газарт балансаар шилжүүлэхийг Анчдын нийгэмлэгийн төв зөвлөл /н.Буяндэлгэр/-д зөвшөөрсүгэй.

✓ 4. Анчдын байнгын бригадын орон тооны ажиллагчдыг 1989 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Тусгай үйлчилгээний автокомбинатын мэдэлд шилжүүлсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРТА

С.МӨНХМАРТАЛ

МОНГОЛЫН АНЧДЫН НИЙГЭМ-
ЛЭГИЙН ТӨВ ЗӨВЛӨЛИЙН
ДАРТА

Ш.БОЛД